



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/451

Хэрлэн сум

“Сэрсэн тал” дуу хөгжмийн наадамд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.5.6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит “Сэрсэн тал” дуу хөгжмийн наадмын хүрээнд зохион байгуулагдаж буй “Орчин үеийн дуу дуулаачдын улсын уралдаан”-д 5,000,000 (таван сая) төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.

2. Тус улсын уралдаанд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх - бидэнд чухал” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ